



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/289

Чингис хот

Техник ажлын зохицуулалтыг хангах
орон тооны бус баг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "а", Боловсролын тухай хуулийн 30.1.2, 30.1.3, 30.1.16 дахь заалт, Их хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан "Үндэсний хөгжлийн цогц бодлого"-ын 4.4, Засгийн газрын 2010 оны 31 дүгээр тогтоолоор батлагдсан "Боловсрол үндэсний хөтөлбөр"-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бэрх хотод Кембрижийн олон улсын ерөнхий боловсролын стандарттай лаборатори сургууль байгуулах зорилгоор бодлогын хэрэгжилтийн техник ажлын зохицуулалтыг хангах орон тооны бус багийг дор дурьдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Багийн ахлагч:	Г.Лхагвахатан	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	С.Мөнхцэцэг	Боловсрол, соёл, урлагийн газрын дарга
Гишүүд:	Д.Өнөрцэцэг	Нийгмийн бодлогын хэлтсийн Боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн
	Д.Цэцэгсүрэн	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн ерөнхий нягтлан бодогч
	Ц.Байгалмаа	Боловсрол, соёл, урлагийн газрын Гадаад хэлний судлагдахуун, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн
	Д.Болорчимэг	Боловсрол, соёл, урлагийн газрын Байгалийн ухааны судлагдахуун, тогтвортой хөгжлийн боловсрол хариуцсан мэргэжилтэн
	Л.Оюунгэрэл	Бэрх хотын Ерөнхий боловсролын сургуулийн захирал

2. Багийн үйл ажиллагааны зардал 1000,0 тэрбум төгрөгийг төвлөрсөн арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т зөвшөөрсүгэй.

3. Багийг ажиллах нөхцөл, үйл ажиллагааны удирдлагаар хангаж ажиллахыг багийн ахлагч /Г.Лхагвахатан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Аймгийн Засаг даргын 2020 оны
06 дугаар сарын 17 өдрийн А/289
дугаар захирамжийн хавсралт

Бэрх хотод Кембрижийн олон улсын ерөнхий боловсролын
стандарттай, хос хэлний олон улсын стандартаар хичээллэх
лаборатори сургууль байгуулах төсөв

№	Үйл ажиллагааны зардал	Төсөв
1	Зөвлөх үйлчилгээ авах зардал	200,0
2	Сурах бичгүүдийг худалдан авах /Тусгай зориулалтын кабинет байгуулах/	300,0
3	Техник тоног төхөөрөмж худалдан авах	300,0
4	Хүүхдийн автобус	100,0
5	Англи хэлний сургалт	100,0
		1000,0